



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/14

Модот

Ажлын хэсэг томилох тухай
(Хужхан багийн төвд стандартын шаардлага
хангасан ариун цэврийн байгууламж, Хурдан морь
хэмжигч төхөөрөмж /лазер/, Түүх соёлын үл хөдлөх
дурсгалыг хаягжуулах хашаажуулах хамгаалах
судлах ажил)

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, 50 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Хужхан багийн төвд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж байгуулах ажил, Хурдан морь хэмжигч төхөөрөмж /лазер/, Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хаягжуулах хашаажуулах хамгаалах судлах ажил ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	У.Гантулга	– Хужхан багийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга	Г.Болор-Эрдэнэ	- Санхүү албаны дарга
Гишүүд	С.Ган-Очир	– Засаг даргын Тамгын газрын нярав

2.Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, байгуулсан гэрээний дагуу гэрээг дүгнэх, хүлээн авах акт үйлдэх, гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгчээр гаргуулж авахыг ажлын хэсгийн ахлагч (У.Гантулга) –д үүрэг болгосугай.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО